



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 10 сарын 01 өдөр

Дугаар А/350

Мандалговь

“Хүүхэд - Хууль 2019” тэмцээнийг зохион  
байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “в”, Цагдаагийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.5, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлан гаргасан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.5, аймгийн Эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, төлөвлөгөөний 1.3.2 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 12 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн сурагч, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнуудад хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг сурталчлан таниулах, хууль эрх зүйн мэдлэг олгох, тэдний багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Хүүхэд - Хууль 2019” тэмцээнийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Тус арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (О.Амарсанаа), аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Б.Түвшинбаяр)-т даалгаж, гарах зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Дээрх арга хэмжээнд шаардагдах 500 500 (Таван зуун мянган таван зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн), нягтлан бодогч (Д.Нандинцэцэг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488190995

Аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар сарын  
...-ний өдрийн .... дугаар захирамжийн хавсралт

**“ХҮҮХЭД- ХУУЛЬ 2019” ТЭМЦЭЭНИЙ ТӨСВИЙН ТООЦОО**

№	Эд зүйлийн нэр	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт зардал
1	Цом	1	30 000	30000
2	Медаль	33	3500	115500
3	Өргөмжлөл	3	30 000	90000
4	Хулдаасан хэвлэл	1	25 000	25000
	<b>Нийт дүн</b>			<b>260500</b>

**МӨНГӨН ШАГНАЛЫН ТӨСВИЙН ТООЦОО**

№	Байр	Мөнгөн шагнал	Дүн
1	Тэргүүн байр	100 000	100000
2	Дэд байр	90 000	80000
3	Гуравдугаар байр	80 000	60000
	<b>Нийт дүн</b>		<b>240000</b>